

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

КАДАСТРЫН ТУХАЙ

/шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт кадастр эрхлэх, бүртгэх, хяналт тавих үйл ажиллагаа болон тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Кадастрын тухай хууль тогтоомж

2.1.Кадастрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын ерөнхий хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль болон эдгээр хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“кадастр” гэж газар, үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хил заагийг зураглах, хаяг, талбай, эзлэхүүн, тоо хэмжээ, төлөв байдал, чанар чадавхыг тогтоох, үнэлгээ хийх, төлбөр, татвар, хураамжийг ногдуулах үндэслэлийг бий болгох, эрх, эрхийн хязгаарлалтыг бүртгэх, баталгаажуулах цогц үйл ажиллагааг;

3.1.2.“кадастрын зураглал” гэж нэгж талбар, түүн дээр орших үл хөдлөх эд хөрөнгийн байршлын солбицол болон хил заагийг тодорхойлох, эргэлтийн цэгийг газарт бэхлэх үйл ажиллагааг;

3.1.3.“кадастрын зураг” гэж нэгж талбар, түүн дээр орших үл хөдлөх эд хөрөнгийн байршил, хэмжээ, хил зааг, зөвшөөрөгдсөн ашиглалтын төрөл, иргэн,

хуулийн этгээд болон газрын эрхийн болон ашиглалтын төрлийн мэдээллийг агуулсан, дахин давтагдашгүй дугаартай, эрх бүхий төрийн байгууллагаас баталгаажсан зургийг;

3.1.4.“нэгж талбар” (парсел) гэж хил зааг, хэмжээ, байршил, газрын эрхийн төрөл болон зөвшөөрөгдсөн ашиглалтын төрөл, иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг агуулсан, дахин давтагдашгүй дугаар бүхий баталгаажсан кадастрын бүртгэлийн нэгжийг;

3.1.5.“дэд нэгж талбар” (плот) гэж нэгж талбар дотор зөвшөөрөгдсөн газар ашиглалтын зориулалтаараа ялгаатай, тодорхой хил зааг бүхий талбайг;

3.1.6.“эргэлтийн цэг” гэж нэгж талбарыг хязгаарласан хилийн шугамын нугаралтыг газарт болон кадастрын зурагт тодорхойлсон цэгийг;

3.1.7.“кадастрын тодорхойлолт” гэж нэгж талбарын талаарх лавлагаа, мэдээллийг;

3.1.8.“кадастрын мэдээллийн нэгдсэн сан” гэж газрын нэгдмэл сангийн тооллого, газрын төлөв байдал, чанар, чадавх, газрын эрхийн кадастрын бүртгэл, хаяг болон газрын үнэлгээ, татвар, төлбөрийн бүртгэлийн өгөгдөл бүхий мэдээллийн санг;

3.1.9.“газрын нэгдмэл сангийн тооллого” гэж газрын нэгдмэл сангийн ангиллын газрын байршил, хил зааг, тоо, хэмжээг тодорхойлох цогц үйл ажиллагааг;

3.1.10.“эрхийн кадастр” гэж газрын эрхтэй этгээд, газар ашиглагчдын газрын эрх, түүний шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг бүртгэж, баталгаажуулах, нотлох үйл ажиллагааг;

3.1.11.“кадастрын судалгаа” гэж кадастрыг эрхлэхэд шаардлагатай мэдээллийг шалган судлах, бүрдүүлэх, нотлох, үнэлэх зорилго бүхий үйл ажиллагааг;

3.1.12.“газрын үнэлгээ хийх” гэж газрын төлөв байдал, чанар, чадавх, эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх үзүүлэлт тус бүрийг харьцуулан үнэлэх үйл ажиллагааг;

3.1.13.“газрын үнэ цэнэ” гэж газрын үнэлгээ хийсний үр дүнд тогтоосон тухайн үеийн үнийг;

3.1.14.“газрын зах зээлийн үнэ” гэж зах зээлд оролцогч талуудын харилцан тохиролцсон үнийг;

3.1.15.“газрын ерөнхий үнэлгээ” гэж газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын газрыг үнэлгээний бүс бүрээр газрын чанар, чадавх, эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлсэн үзүүлэлт, газрын зах зээлийн үнийг харьцуулан загварчилж, газрын суурь үнийг тогтоох үйл ажиллагааг;

3.1.16.“суурь үнэ” гэж тухайн суурь үнийн бүс дэх нэгж талбаруудын үнийн дунджийг;

3.1.17.“суурь үнийн бүс” гэж суурь үнийг баримтлах тодорхой нутаг дэвсгэрийн хил заагийг;

3.1.18.“газрын үнэлгээний мэдээллийн сан” гэж газрын үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг агуулсан кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн дэд санг.

4 дүгээр зүйл.Кадастрын үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1.Кадастрын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална.

4.1.1.мэргэжлийн тусгай програм хангамжид тулгуурласан байх;

4.1.2.мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх;

4.1.3.кадастрын мэдээллийн нэгдсэн санд суурилсан байх;

4.1.4.ил тод, хараат бус, тэгш оролцоог хангасан байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ КАДАСТР ЭРХЛЭХ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

5 дугаар зүйл. Кадастр

5.1.Газрын ерөнхий хуулийн 97.3-т заасны дагуу олон зориулалтат кадастрыг эрхэлнэ.

5.2.Кадастрыг улсын хэмжээнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүрэгт аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, суманд газрын даамал тус тус эрхэлнэ.

5.3.Кадастрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, кадастр эрхлэх, гүйцэтгэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

5.4.Кадастрын зураглал, судалгаа, үнэлгээний ажлыг төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын захиалгаар холбогдох журмын дагуу кадастр эрхлэх нөхцөл, шаардлага хангасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ.

5.5.Кадастрын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий мэргэжлийн байгууллага нь кадастрын зураглал, түүний боловсруулалтын үр дүнг кадастрын мэдээллийн нэгдсэн санд оруулна.

6 дугаар зүйл. Кадастрын талаар төрийн байгууллагын чиг үүрэг

6.1.Засгийн газар кадастрыг эрхлэхтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.кадастрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.2.кадастрын ажлын үнэлгээг батлах;

6.1.3.газрын ерөнхий үнэлгээ хийх журмыг батлах;

6.1.4.эрхийн кадастр хийх журмыг батлах;

6.1.5.газрын суурь үнэ, бүсийн хил заагийг улсын хэмжээнд тогтоох;

6.1.6.газрын нэгдмэл сангийн тооллого явуулах, мэдээллийн сан хөтлөх журмыг батлах;

6.1.7.кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журмыг батлах;

6.1.8.кадастрын үйл ажиллагааны хураамжийн хэмжээг тогтоох;

6.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

6.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага кадастр эрхлэхтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1.кадастрын зураглалын стандарт, технологийн аргачлал, дүрэм, журмыг батлах;

6.2.2.нэгж талбар дугаарлах журмыг батлах;

6.2.3.газрын ерөнхий үнэлгээ хийх аргачлалыг батлах;

6.2.4.кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох;

6.2.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага кадастр эрхлэхтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1.кадастрыг улсын хэмжээнд эрхлэх, удирдах, зохион байгуулах;

6.3.2.кадастрын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, лавлагаа гаргах, нийтэд үйлчлэх үйл ажиллагааг зохицуулах;

6.3.3.кадастрын мэдээллийн нэгдсэн санг ажиллуулах журмыг батлах;

6.3.4.кадастрын ажлыг захиалах, захиалагчийн хяналт хийх, хүлээн авах;

6.3.5.кадастртай холбоотой маргааныг таслах, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргах;

6.3.6.газрын нэгдмэл сангийн тайланг улсын хэмжээнд гаргаж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн Засгийн газарт тайлагнах;

6.3.7.кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авах, олгох, цуцлах саналыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн мэдээллийн санг эрхлэх;

6.3.8.кадастрын зургийн масштаб, нарийвчлал, загварыг батлах;

6.3.9.нэгж талбарын хувийн хэргийг үүсгэх, хөтлөх журмыг батлах;

6.3.10.кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, ашиглуулах журмыг батлах;

6.3.11.хориглох дохио тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг батлах;

6.3.12.эргэлтийн цэгийн байрлалыг газар дээр нь тэмдэглэн бэхжүүлэх тэмдэгтийн загвар, хэмжээ, үйлдэх, суулгах журмыг батлах;

6.3.13.газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулах ажлыг зохион байгуулах;

6.3.14.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

6.4.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага кадастр эрхлэхтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.4.1.кадастрын мэдээллийн нэгдсэн санг зохих журмын дагуу хөтлөх, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх;

6.4.2.газрын нэгдмэл сангийн тайланг харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохих журмын дагуу гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад тайлагнах;

6.4.3.иргэн, хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрх болон газар өмчлөх эрхийг шинээр олгох, газрын хязгаарлагдмал эрхэд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шийдвэр гаргах;

6.4.4. газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээ олгох;

6.4.5.хуульд заасан бусад чиг үүрэг.

6.5.Сумын газрын даамал, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага кадастрыг эрхлэхтэй холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.5.1.иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч энэ хуулийн 7.1.4-д заасан журмын дагуу шийдвэрлүүлэх;

6.5.2.эрх бүхий этгээдийн газрын харилцааны талаарх шийдвэрийн төслийг боловсруулах, гарсан шийдвэрийг үндэслэн иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах;

6.5.3.энэ хуулийн 5.5-д заасан мэдээллийг хянаж, кадастрын мэдээллийн нэгдсэн санд баталгаажуулах;

6.5.4. тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт эрх бүхий этгээдийн шийдвэрээр байгуулсан газар ашиглалтын гэрээг заасан хугацаанд нь дүгнэх, холбогдох арга хэмжээг авах, цуцлах саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх, шийдвэрлүүлэх;

6.5.5.кадастрын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагын кадастрын мэдээллийн нэгдсэн санд оруулсан кадастрын зураглал, түүний боловсруулалтын үр дүнг шалгах, баталгаажуулах;

6.5.6.кадастрын мэдээллийн нэгдсэн санг зохих журмын дагуу эрхэлж олон нийтэд үйлчилгээ үзүүлэх;

6.5.7.газрын нэгдмэл сангийн тайланг зохих журмын дагуу гаргаж сум, дүүргийн Засаг даргад тайлагнах;

6.5.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

7 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

7.1.Иргэн, хуулийн этгээд кадастртай холбоотой дараах эрх эдэлнэ:

7.1.1.газрын эрх авах, газар ашиглах хүсэлтээ илэрхийлэх;

7.1.2.газрын эрхтэй этгээд, газар ашиглагч өөрийн газрын талаар тодорхойлолт авах;

7.1.3.хууль тогтоомжид заасан бусад эрх.

7.2.Иргэн, хуулийн этгээд кадастртай холбоотой дараах үүрэг хүлээнэ:

7.2.1.газрын эрхтэй этгээд, газар ашиглагч өөрийн хөрөнгөөр кадастр хийлгэх;

7.2.2.газрын эрхтэй этгээд, газар ашиглагч нь газрын кадастрын үйл ажиллагаагаар тогтоогдсон хил зааг, түүний эргэлтийн цэг болон шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 6.3.11-т заасан хориглох дохио тэмдгийг өөрийн хөрөнгөөр газарт бэхлэх, дур мэдэн өөрчлөхгүй байх, түүнийг гадны ямар нэгэн нөлөөллөөр хөдөлгөөнд орох, устаж гэмтэхээс хамгаалах;

7.2.3.газрын эрхтэй этгээд, газар ашиглагч нь газар болон түүний ойр орчимд байрлаж байгаа геодезийн цэг, тэмдэгтийг гадны нөлөөллөөр хөдөлгөөнд орох, устаж гэмтэхээс хамгаалах;

7.2.4.хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүрэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТООЛЛОГО

8 дугаар зүйл. Газрын нэгдмэл сангийн тооллого, түүнд хамаарах үзүүлэлт

8.1.Газрын нэгдмэл сангийн тооллого нь Газрын ерөнхий хуулийн 2 дугаар бүлэгт заасан үндсэн болон дэлгэрэнгүй ангилалд хамаарч байгаа газрын нэгдмэл сангийн зураглал, түүн дээр үндэслэсэн бүртгэлээс бүрдэнэ.

8.2.Газрын нэгдмэл сангийн бүртгэлийг дараах үзүүлэлтээр хөтөлнө:

8.2.1.нэгж талбарын дугаар;

8.2.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, код;

8.2.3.газрын кадастрын муж, тойргийн нэр, дугаар;

8.2.4.газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, код;

8.2.5.газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал, код;

8.2.6.газар ашиглалтын зориулалт, код;

8.2.7.талбайн хэмжээ.

9 дүгээр зүйл. Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг хөтлөх

9.1.Газрын нэгдмэл сангийн тооллогоор үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын зураглал үйлдэж, тэдгээрийн байршил, талбайн хэмжээг тодорхойлж, газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг бүрдүүлнэ.

9.2.Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг газрын эрхээс үл хамааран засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын дагуу хөтөлнө.

9.3.Газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт бүрийг кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажуулна.

9.4.Газрын нэгдмэл сангийн тооллогыг 5 жил тутамд хийнэ.

9.5.Нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн тооллогыг тухайн шатны Засаг даргын болон газрын эрхтэй этгээд, газар ашиглагчийн захиалгаар хугацаа харгалзахгүйгээр хийж болно.

10 дугаар зүйл. Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах

10.1.Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд дараах тохиолдолд өөрчлөлт оруулна:

10.1.1.энэ хуулийн 9.4-т заасан тооллогын үр дүнгээр;

10.1.2.газрын нэгдмэл сангийн үндсэн, дэлгэрэнгүй ангиллыг энэ хууль болон Газрын ерөнхий хуулийн дагуу өөрчлөх шийдвэр гарсан;

10.1.3.газрын эрхтэй этгээд, газар ашиглагч нь газар ашиглалтын зориулалтаа өөрчлүүлэх хүсэлт гаргасны дагуу уг асуудлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэсэн.

11 дүгээр зүйл. Газрын нэгдмэл сангийн ангилалд өөрчлөлт оруулах

11.1.Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал шилжүүлэх тухай шийдвэрийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

11.2.Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал шилжүүлэх тухай шийдвэрийг газар зохион байгуулалтын ерөнхий болон жилийн төлөвлөгөөний дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.

12 дугаар зүйл. Ашигт малтмал ашиглах эрхлэх нөхцөл шаардлагыг хангасан талбайд ашигт малтмал олборлох зориулалтаар газрын ангилал шилжүүлэх

12.1.Зохих журмын дагуу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд нь уг эрхийг авснаас хойш 1 сарын дотор аймаг, нийслэл, дүүргийн

гхзрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон сумын газрын даамалд ашигт малтмал ашиглах зориулалтаар газар ашиглалтын гэрээгээр ашиглах тухай хүсэлт гаргана.

12.2.Хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

12.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

12.2.2.ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн хуулбар;

12.2.3.уурхайн ашиглалтын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.

12.3.Аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон сумын газрын даамал энэ зүйлийн 13.2-т заасан хүсэлтэд дурдсан газар нь эрх үүссэн газартай давхцсан тохиолдолд газрын эрхтэй этгээд, газар ашиглагчтай газрыг нь буцаан авах болзол, нөхцөл, нөхөх олговрын хэмжээг харилцан тохиролцоно.

12.4.Газрын эрхтэй этгээд, газар ашиглагчдад олгох нөхөх олговрыг хүсэлт гаргагч хариуцан ашигт малтмал олборлолт эхлэхээс өмнө төлнө.

12.5.Газрын эрхтэй этгээд, газар ашиглагчдад нөхөх олговор олгосны дараа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх тухай мэдэгдлийг хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

12.6.Газар ашиглалтын гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах, гэрчилгээ олгох, гэрээ байгуулах, эрхийн кадастрт бүртгэх харилцааг энэхүү хуулиар зохицуулна.

12.7.Газар ашиглалтын гэрээгээр ашиглуулах шийдвэрт газрын нэгдмэл сангийн ангилал өөрчлөх асуудлыг тусгана.

12.8.Энэ хуулийн 12.7-д заасан шийдвэрийг үндэслэн газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

3 дугаар зүйл. Хот, тосгон бусад суурин газрын хилийн заагийг өөрчлөхөд газрын ангилал шилжүүлэх

13.1.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хот, тосгон бусад суурин газрын хилийн заагийг шинээр тогтоох, өөрчлөх саналыг тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хамт газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

13.1.1.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага саналыг судлан үзээд дүгнэлт гарган уг асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлуулан Засгийн газарт хүргүүлнэ.

13.1.2.дүгнэлтэд хот, тосгон бусад суурин газрын хилийн заагийг шинээр тогтоох, өөрчлөх үндэслэл, шаардлагыг дэлгэрэнгүй тусгаж, хилийн заагийг харуулсан зураг, шилжүүлэх үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын газрын хэмжээг тодорхойлж хавсаргана.

13.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг үндэслэн шинээр тогтоосон буюу өөрчилсөн хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, эргэлтийн цэгүүдийн солбицлыг тодорхойлон аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба болон сумын газрын даамалд актаар хүлээлгэн өгнө.

13.3.Нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлж байгаа газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын талбайн хэмжээг үндэслэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Газрын алба нь газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулна.

14 дүгээр зүйл. Улсын чанартай авто зам, шугам сүлжээ, төмөр замын суурь бүтэц шинээр байгуулахад газрын ангилал шилжүүлэх

14.1.Холбогдох төрийн захиргааны байгууллага болон хуулийн этгээд нь улсын чанартай авто зам, шугам сүлжээ, төмөр замын суурь бүтэц шинээр байгуулах тухай хүсэлтээ газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргана.

14.2.Хүсэлтэд дараах зураг, материалыг хавсаргана:

14.2.1.төлөвлөж байгаа зам, шугам сүлжээ, төмөр замын суурь бүтцийн байршлын зураг;

14.2.2.техник, эдийн засгийн үндэслэл.

14.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох байгууллагатай хамтран хүсэлтэд дурдсан газрын байршил, хэмжээг шаардлагатай тохиолдолд газар дээр нь хэмжилт хийж, газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын талбайн хэмжээг тооцож, дүгнэлтийн хамт газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.4.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага асуудлыг судалж, дүгнэлт гарган Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

14.5.Улсын чанартай авто зам болон шугам сүлжээ шинээр байгуулахтай холбогдуулан Засгийн газраас ангилал өөрчлөх тухай гаргасан шийдвэрийг газар дээр нь хэрэгжүүлж бүртгэх, мэдээллийн санд оруулах ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

15 дугаар зүйл. Газрын төлөв байдал, чанар, чадавхын бүртгэл, хамаарах үзүүлэлт

15.1.Газрын төлөв байдал, чанар, чадавхын бүртгэл дараах мэдээллийг агуулсан нэгж талбар бүрийн зураг, түүн дээр үндэслэсэн бүртгэлээс бүрдэнэ:

15.1.1.хөрс;

15.1.2.ургамал;

15.1.3.газар хөдлөлт;

- 15.1.4.газрын гадаргуу;
- 15.1.5.өндөржилт;
- 15.1.6.налуужилт;
- 15.1.7.зүг зовхис;
- 15.1.8.байгаль, цаг уурын муж;
- 15.1.9.газрын доорх ус;
- 15.1.10.инженер геологи;
- 15.1.11.газрын доорх ашигт малтмал;
- 15.1.12.газрын доорх байгалийн хий.

15.2.Газрын төлөв байдал, чанар, чадавхын бүртгэл нь кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэнээр баталгаажна.

15.3.Газрын төлөв байдал, чанар, чадавхын бүртгэлд мэдээлэл тус бүрээр тусгах үзүүлэлт, зургийн масштаб, нарийвчлал, тэдгээрийг бүрдүүлэх, хөтлөх журмыг Засгийн газар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЭРХИЙН КАДАСТР

16 дугаар зүйл. Нэгж талбар

16.1.Нэгж талбар нь эрхийн кадастрын нэгж байна.

16.2.Нэгж талбар бүр дугаартай, дугаар нь улсын хэмжээнд дахин давтагдахгүй байна.

16.3.Нэгж талбарыг газар ашиглалтын зориулалтаас нь хамааран дэд нэгж талбаруудад хувааж болно. Дэд нэгж талбар нь хил заагтай байна.

16.4.Хил зааг, тэдгээрийн эргэлтийн цэгийн байрлалыг байгалийн байнгын биет, хүний бүтээсэн байгууламж, тусгай тэмдэгтийг ашиглан газар дээр нь тэмдэглэж, кадастрын зурагт буулгана.

17 дугаар зүйл. Эрхийн кадастр, түүнд хамаарах үзүүлэлт

17.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу үүссэн газрын эрх, газар ашиглах гэрээг эрхийн кадастрт бүртгүүлнэ.

17.2.Эрхийн кадастр нь Газрын ерөнхий хуулийн 97.5-д заасан эрхтэй холбоотой мэдээллийг агуулна:

17.3.Эрхийн кадастр нь байрлалд суурилсан бүртгэлийн мэдээллээс бүрдэх бөгөөд Газрын ерөнхий хуульд заасан мэдээллийг бүртгэнэ.

17.4.Нэгж талбар бүрийг эрхийн кадастрт бүртгэж, эрхийн гэрчилгээ олгоно.

17.5.Эрхийн кадастрын хуулиар хориглосноос бусад мэдээлэл нээлттэй байна.

18 дугаар зүйл. Эрхийн кадастр

18.1.Эрхийн кадастрт дараах үйл ажиллагаа хамаарна.

- 18.1.1.шинээр газрын эрх олгох;
- 18.1.2.газрын эрхийг бусдад шилжүүлэх;
- 18.1.3.газрын эрхийг хэсэгчлэн шилжүүлэх;
- 18.1.4.газрын зориулалтыг өөрчлөх;
- 18.1.5.газрын талбайн хэмжээг өөрчлөх;
- 18.1.6.газрын эрхийг барьцааг бүртгэх;
- 18.1.7.газрын эрхийг бусдад ашиглуулах;
- 18.1.8.газрын эрхийн хугацаа сунгах;
- 18.1.9.газрын эрхийн гэрчилгээ нөхөн олгох;
- 18.1.10.газрын эрхийг нөхөн олговортойгоор эргүүлэн авах;
- 18.1.11.газрын эрхийг дуудлага худалдаагаар олгох
- 18.1.12.газрын эрхийг төсөл сонгон шалгаруулалтаар олгох;
- 18.1.13.улсын тусгай хамгаалалтай газар нутагт газар ашиглуулах;
- 18.1.14.чөлөөт бүсийн газар нутагт газар ашиглуулах;
- 18.1.15.газрын эрхийг дуусгавар болгох;
- 18.1.16.газрын эрхийг хүчингүй болгох;
- 18.1.17.газрын эрхийг шүүхийн шийдвэрээр цуцлах, сэргээх;
- 18.1.18.хаягийн мэдээлэл өөрчлөгдөх.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан ажиллагааг дараах дэс дараалал /кадастр хийлгэх/-аар гүйцэтгэнэ.

- 18.2.1.кадастр хийлгэх хүсэлт хүлээн авах, хариу мэдэгдэх;
- 18.2.2.кадастрын судалгаа хийх;

18.2.3.кадастрын хээрийн хэмжилтэд бэлтгэх, гүйцэтгэх, хэмжилтийн үр дүнг боловсруулах, Кадастрын мэдээллийн нэгдсэн санд оруулах;

18.2.4.нэгж талбар, түүн дээрх үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах;

18.2.5.эрх бүхий этгээдийн шийдвэр гаргах;

18.2.6.улсын бүртгэлд бүртгэх;

18.2.7.гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, газрын төлбөр, татварыг ногдуулах;

18.2.8.нотлох баримт, материалаар нэгж талбарын цаасан болон цахим хувийн хэрэг үүсгэн архивлах.

18.3.Шинээр газрын эрх олгохдоо энэ хуулийн 18.2.1-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.4.Газрын эрхийг бусдад шилжүүлэхэд энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.5, 18.2.6-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.5.Газрын эрхийг хэсэгчлэн шилжүүлэхэд энэ хуулийн 18.4-ийн дагуу гүйцэтгэнэ.

18.6.Газрын зориулалт өөрчлөхөд энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.5, 18.2.6-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.7.Газрын талбайн хэмжээг өөрчлөхдөө энэ хуулийн 18.2.1-18.2.3, 18.2.5-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.8.Газрын эрхийг барьцаанд бүртгэхэд энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.6-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.9.Газрын эрхээ бусдад ашиглуулахдаа энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.5-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.10.Газрын эрхийн хугацаа сунгахад энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.5, 18.2.7, 18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.11.Газрын эрхийн гэрчилгээ нөхөн авахад энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.7, 18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.12.Газрын эрхийг нөхөн олговортойгоор эргүүлэн авахад энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.13.Газрын эрхийг дуудлага худалдаагаар олгоход энэ хуулийн 18.2.1, 18.2.4-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.14 Газрын эрхийг төсөл сонгон шалгаруулалтаар олгоход энэ хуулийн 18.2.1, 18.2.4-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.15.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулахад энэ хуулийн 18.2.1-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.16.Чөлөөт бүсийн газар нутагт газар ашиглуулахад энэ хуулийн 18.2.1-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.17.Газрын эрхийг давуу эрхээр олгоход энэ хуулийн 18.2.1-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.18.Газрын эрхийг дуусгавар болгоход энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.5, 18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.19.Газрын эрхийг хүчингүй болгоход энэ хуулийн 18.2.2, 18.2.3, 18.2.5, 18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.20.Газрын эрхийг шүүхийн шийдвэрээр цуцлах ба сэргээхэд энэ хуулийн 18.2.1-18.2.3, 18.2.5-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.21.Нэгж талбарын хаягийн мэдээллийг өөрчлөхөд энэ хуулийн 18.2.1, 18.2.2, 18.2.4, 18.2.6-18.2.8-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

18.22.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг Эрхийн кадастр хийх журмаар зохицуулна. Эрхийн кадастр хийх журмыг Засгийн газар батална.

19 дүгээр. Газрын эрхийг кадастрын бүртгэлд бүртгэх

19.1.Газрын хязгаарлагдмал эрх, өмчлөх эрх олгох, өөрчлөх, дуусгавар болгох тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн эрхийн төрөл харгалзахгүйгээр нэгж талбар бүрээр кадастрын бүртгэлд бүртгэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ҮНЭЛГЭЭ, ТАТВАР, ТӨЛБӨР

20 дугаар зүйл. Газрын үнэлгээний зүйл, төрөл, аргачлал

20.1.Газрын үнэлгээний зүйлд газар, түүний дээр салшгүй бэхлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө хамаарна.

20.2.Газрын үнэлгээ нь дараах төрөлтэй байна:

20.2.1.ерөнхий үнэлгээ;

20.2.2.нэг бүрчилсэн үнэлгээ.

20.3.Ерөнхий үнэлгээг газрын суурь үнэ тогтооход, нэг бүрчилсэн үнэлгээг тодорхой зорилгоор газрын үнэ цэнэ тогтооход хийнэ.

20.4.Нэг бүрчилсэн үнэлгээг газрын шинж байдал, онцлог, зориулалтыг харгалзан үнэлгээний олон улсын болон үндэсний стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон энэ хуулийн 20.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.

20.5.Ерөнхий үнэлгээг энэ хуулийн 6.1.3-т заасан журмын дагуу хийнэ.

20.6. Газрын нэг бүрчилсэн үнэлгээ хийх аргачлалыг газрын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

21 дүгээр зүйл. Газрын ерөнхий үнэлгээ

21.1.Газрын ерөнхий үнэлгээгээр газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллын газрыг үнэлгээний бүс бүрээр газрын чанар, чадавх, эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлсэн үзүүлэлт, газрын зах зээлийн үнийн мэдээг харьцуулан загварчилж, газрын суурь үнэ, бүсийг тодорхойлно.

21.2.Газрын ерөнхий үнэлгээг кадастрын мэдээллийн санд үндэслэн, хот, тосгон, бусад суурины газарт 3 жил тутамд, бусад ангиллын газарт 5 жил тутамд хийнэ.

21.3.Шинээр хот суурин газар үүссэн, тэлсэн, дахин төлөвлөлт хийсэн зэрэг шаардлагатай тохиолдолд тусгайлсан үнэлгээ хийж болно. Тусгайлсан үнэлгээг энэ хуулийн 20.5-д заасан журмаар хийнэ.

21.4.Газрын ерөнхий үнэлгээ хийх ажиллагааг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах дарааллын дагуу зохион байгуулна:

21.4.1.газрын ерөнхий үнэлгээгээр тогтоосон газрын суурь үнэ, бүсийн хил заагийг урьдчилсан байдлаар боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэд, олон нийтэд мэдээлэх;

21.4.2.газрын суурь үнэ, бүсийн хил заагийг энэ хуулийн 22.2-т заасан хугацаанд Засгийн газарт хүргүүлж, батлуулах;

21.4.3.газрын суурь үнэ, бүсийн хил заагийг кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, нийтэд мэдээллэх.

22 дугаар зүйл. Газрын үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, хүлээн авах, шалгах

22.1.Газрын үнэлгээнд газрын чанар, чадавх, эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлсэн дараах мэдээллийг ашиглана.

22.1.1.кадастрын мэдээллийн сан;

22.1.2.байр зүйн зураг;

22.1.3.агаарын ортофото болон сансрын зураг;

22.1.4.газар зохион байгуулалтын үндсэн баримт бичгийн мэдээлэл;

22.1.5.бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үр дүн;

22.1.6.тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үр дүн;

22.1.7.хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үр дүн;

22.1.8.газрын нэгдмэл сангийн тооллого, тоо бүртгэл;

22.1.9.нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтэц, инженерийн хангамжийн мэдээлэл;

22.1.10.газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ;

22.1.11.ойн мужлал, усны ай сав газрын хил зааг болон ой, усны экологи-эдийн засгийн үнэлгээний мэдээлэл;

22.1.12.газарт оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг тусгасан техник эдийн засгийн үзүүлэлтийн тайлан, мэдээлэл;

22.1.13.бусад.

22.2.Энэ хуулийн 22.1.1, 22.1.8-д заасан мэдээллийг кадастрын мэдээллийн санг үндэслэн бүрдүүлнэ.

22.3.Энэ хуулийн 22.1.2-22.1.7, 22.1.9-д заасан мэдээллийг орон зайн өгөгдлийн дэд бүтцэд үндэслэн бүрдүүлнэ.

22.4.Хөрсний үржил шимийг бүрдүүлэгч гол үзүүлэлтүүд, газарзүй болон байгаль цаг уурын онцлог, тогтоц, таримал, ургамлын гарал үүсэл, төрөл, газрын чадавх зэрэг мэдээллийг тухайн оны газрын төлөв, байдал чанарын хянан баталгааны мэдээг үндэслэн бүрдүүлнэ.

22.5.Ой, усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газар, улсын тусгай хэрэгцээний газрын үнэлгээ хийхтэй холбоотой мэдээллийг холбогдох төрийн захиргааны байгууллага нь газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

22.6.Энэ хуулийн 21.2-т заасан хугацаанд газрын биржид бүртгэгдсэн газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг ашиглахдаа энэ хуулийн 21.2-т заасан хугацааг баримтлана.

23 дугаар зүйл. Газрын үнэлгээний мэдээллийн сан

23.1.Газрын үнэлгээний мэдээллийн сан нь газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнэ, суурь үнэ, үнэлгээний бүс болон энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан газрын үнэлгээнд нөлөөлөгч хүчин зүйлээс бүрдэнэ.

23.2.Газрын үнэлгээний мэдээллийн санг эрхлэх журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

24 дугаар зүйл. Газрын албан татварын бүртгэл

24.1.Газрын албан татварын бүртгэлийг Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу газар өмчилж байгаа иргэн тус бүрээр газрын татвар, төлбөрийн мэдээллийн санд дараах үзүүлэлтээр бүртгэнэ:

- 24.1.1.төлөх татварын хэмжээ;
- 24.1.2.төлсөн татварын хэмжээ;
- 24.1.3.хөнгөлсөн татварын хэмжээ;
- 24.1.4.чөлөөлсөн татварын хэмжээ;
- 24.1.5.илүү төлсөн татварын хэмжээ;
- 24.1.6.дутуу төлсөн татварын хэмжээ;
- 24.1.7.алданги;
- 24.1.8.торгуулийн хэмжээ.

24.2.Газрын татвар ногдуулах, хураах, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

25 дугаар зүйл. Газрын төлбөрийн бүртгэл

25.1.Газрын төлбөрийн бүртгэлийг газрын эрхтэй этгээд, газар ашиглагч тус бүрээр газрын татвар, төлбөрийн мэдээллийн санд дараах үзүүлэлтээр нэмж бүртгэнэ:

- 25.1.1.төлөх төлбөрийн хэмжээ;
- 25.1.2.төлсөн төлбөрийн хэмжээ;
- 25.1.3.хөнгөлсөн төлбөрийн хэмжээ;
- 25.1.4.чөлөөлсөн төлбөрийн хэмжээ;
- 25.1.5.илүү төлсөн төлбөрийн хэмжээ;
- 25.1.6.дутуу төлсөн төлбөрийн хэмжээ;

25.1.7.алданги;

25.1.8.торгуулийн хэмжээ.

25.1.Газрын төлбөр ногдуулах, хураах, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

26 дугаар зүйл. Кадастрын мэдээллийн нэгдсэн сан

26.1.Кадастрын мэдээллийн нэгдсэн сан, түүний өгөгдлийн дизайн, програм хангамж, тоног төхөөрөмж, сүлжээ нь Газрын ерөнхий хуулийн 25.1-д заасан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн бүрэлдэхүүн хэсэг байна.

26.2.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цахим хэлбэрээр бүрдүүлэх, хөгжүүлэх боломжтой байна.

26.3.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, эх нотлох баримт бичгийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сумын газрын даамал хүлээнэ.

26.4.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ажлын шаардлагаар ашиглаж байгаа этгээд тухайн мэдээлэлтэй холбоотой хуулиар тогтоосон нууцыг хадгалах үүрэгтэй.

27 дугаар зүйл. Төрийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт

27.1.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн хуулбар сан нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад хадгалагдана.

27.2.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн үнэн зөв байдал, баяжилт, шинэчлэл, хадгалалт, хамгаалалтыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

27.3.Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллага хуулбар сангийн аюулгүй байдлыг хариуцана.

28 дугаар зүйл. Кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас мэдээлэл солилцох, ашиглах

28.1.Кадастрын мэдээллийн нэгдсэн сан нь төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад үүсгэсэн дундын мэдээллийн сангаар дамжуулан төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцоно.

28.2.Кадастрын мэдээллийн нэгдсэн сан нь төрийн цахим мэдээлэл сангаас харилцан мэдээлэл солилцохдоо төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, нууцлалт, хамгаалалтын шаардлага хангасан байна.

28.3.Эрх бүхий этгээдийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд олгогдож буй газрын эрхийн бүртгэлийн мэдээллийг Кадастрын нэгдсэн системд бүртгэж баталгаажуулж, харилцан мэдээлэл солилцоно.

28.4.Кадастрын мэдээллийн нэгдсэн санд хуулиар хориглосноос бусад мэдээллийг цахимаар нээлтэй болон төлбөртэйгээр олгохоор байршуулна.

28.5.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хуулийн этгээд, төрийн бус байгууллагатай мэдээлэл солилцох, ашиглуулах асуудлыг энэ хуулийн 7.3.12-д заасан журмаар зохицуулна.

28.6.Кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас бусад байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох тохиолдолд тоон гарын үсэг ашиглана.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

29 дүгээр зүйл. Кадастрын хяналт шалгалт болон магадлан хэмжилт

29.1.Аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын газрын даамал болон газрын кадастрыг хийх эрхлэх нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдийн гүйцэтгэсэн кадастрын хэмжилт, зураглалын ажилд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага магадлан хэмжилт хийнэ.

29.2.Кадастрын хэмжилтийн үр дүнг шалгах арга технологи болон үйл ажиллагааны заавар, журмыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

30 дүгээр зүйл. Кадастрын үйл ажиллагаанд хориглох зүйл

30.1.Кадастрын талаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

30.1.1.газрын эрхтэй этгээд, газар ашиглагч нь газартаа геодезийн цэг, тэмдэгт болон нэгж талбарын хил заагийн эргэлтийн цэгийн тэмдэглээсийг гэмтээх, устгах, зөвшөөрөлгүйгээр нүүлгэн шилжүүлэх;

30.1.2.аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сумын газрын даамал нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр кадастрын мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, мэдээллийг засварлах, бусдад дамжуулах;

30.1.3.газар дээр хэмжилт хийлгүй мэдээллийн сангийн график мэдээлэлд өөрчлөлт оруулах;

30.1.4.нэгж талбарын хувийн хэргийн мэдээллийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр иргэн, хуулийн этгээдэд өгөх;

30.1.5.газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас холбогдох лавлагаа авалгүй газрын эрх, газар ашиглахтай холбоотой шийдвэр гаргах, нэгж талбарт өөрчлөлт оруулах, газрын эрхийг шилжүүлэх.

31 дугаар зүйл. Маргааныг хянан шийдвэрлэх

31.1.Кадастртай холбогдсон маргааныг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

32 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

32.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

33 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

33.1.Энэ хуулийг 20.... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг